Газар хөдлөлтийн үед нөхцөл байдалд тохируулан өөрийгөө хамгаалах арга

Газар хөдлөх агшинд зохих шийдвэр гаргахад хэцүү байдаг тул ердийн үед газар хөдлөлтөөс өөрийгөө хэрхэн хамгаалах талаар мэдэж бэлтгэлтэй байх хэрэгтэй.

행정안전부 Ministry of the Interior and Safety
여성가족부 Ministry of Gender Equality and Family
한국건강가정진흥원 KOREAN INSTITUTE FOR HEALTHY FAMILY

Газар хөдөлж чичирхийлэх үед :

Чичирхийлэлтийн турш ширээн дор орж, биеэ хамгаалах ба ширээний хөлнөөс барих

Газар хөдлөлтийн дараа :

Газар хөдлөлт зогсоход цахилгаан болон хийг салгаж, гарах хаалгаа онгойлгох

Байшингаас гарахад :

Байшингаас гарахдаа шат ашиглан түргэн гарах
(Лифт ашиглах хориотой)

※Лифтинд явж байсан бол бүх давхарын товчийг дарж, түрүүлж нээгдсэн давхарт буухлифт.

Байшингаас гарсны дараа :

Гадаа байхдаа цүнх юмуу гараараа толгойгоо хамгаалах ба байшингаас холдон эргэн тойрноо ажиглан аюулгүй газар олох

Хоргодох газар олоход :

Дээрээс юм унаж болзошгүй тул сэрэмжтэй байх ба биеийн тамирын талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэг нээлттэй том задгай талбай руу явах
(Машинаар явахыг хориглоно)

Хоргодох газарт ирсний дараа :



Радио, төр захиргааны байгууллагаас өгч буй зөв бодит мэдээлэлд анхаарлаа хандуулах

Газар хөдлөлтийн үед байгаа газраасаа шалтгаалан өөрийгөө хамгаалах арга

Газар хөдлөх агшинд зохих шийдвэр гаргахад хэцүү байдаг тул ердийн үед газар хөдлөлтөөс өөрийгөө хэрхэн хамгаалах талаар мэдэж бэлтгэлтэй байх хэрэгтэй.

행정안전부 Ministry of the Interior and Safety
여성가족부 Ministry of Gender Equality and Family
한국건강가정진흥원 KOREAN INSTITUTE FOR HEALTHY FAMILY

Газар хөдлөх үед гэртээ байгаа бол :

Ширээн дор орон биеэ хамгаална. Чичиргээ зогсоход цахилгаан, хийгээ салгаж, хаалгаа онгойлгон гадагш гарах

Газар хөдлөх үед гадна байгаа бол :

Дээрээс юм унаж болзошгүй тул цунх, гараар толгойгоо хамгаалан барилга байшингаас холдон биеийн тамирын талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэг нээлттэй задгай талбайд хоргодох

Газар хөдлөх үед лифтинд байсан бол :

Бүх давхарын товчийг дарах ба хамгийн түрүүнд нээгдсэн давхарт буусны дараа шат ашиглах

※Газар хөдлөлтийн үед лифтэнд сууж болохгүй.

Газар хөдлөх үед сургууль дээр байсан бол :

Ширээн дор орж ширээний хөлнөөс барина. Чичирхийлэлт зогсоход биеийн тамирын талбайд хоргодох

Газар хөдлөлтийн үед их дэлгүүр, супермаркетд байсан бол :

Тавиураас унаж болзошгүй зүйлээс биеэ хамгаалан шат, багананы ойр очих ба чичирхийлэлт зогсоход гадагш гарах

Газар хөдлөлтийн үед театр, стадион зэрэг газарт байгаа бол :



Чичирхийлэлт зогстол цунх зэрэг өөрт буй зүйлээр биеэ хамгаалан хүлээж байгаад тухайн газрын ажилтны зааврын дагуу тайван хоргодох газар руу явах

Газар хөдлөлтийн үед метронд байсан бол :

Гарын бариул, багана зэргээс барьж, унахаас болгоомжилно. Метро зогсоход тухайн газрын ажилтны зааврыг дагах

Газар хөдлөлтийн үед машинаар явж байсан бол :

Аваарын гэрлийг асаан хурдаа сааруулан замын баруун талд машинаа зогсоон радиогоор өгч буй мэдээллийг сайтар сонсонгоо түлхүүрээ машиндаа зоох ба хоргодох

Газар хөдлөлтийн үед уул, далайгаар явж байсан бол :

Уул, хад цохио нурахаас сэргийлж, аюулгүй газарт хоргодох ба далайн эрэгт далайн давалгаа хаялга ширүүсэх тухай мэдээлэхэд өндөр газар руу холдох